



МОНГОЛ УЛС
ТӨВ АЙМАГ ДАХЬ ЦАГДААГИЙН ГАЗРЫН ДАРГЫН
ТУШААЛ

2016 оны 10 сарын 18 өдөр

Дугаар А/40.

Зуунмод

Г Өвлийн улиралын дүрэмт хувцсанд
шилжүүлэх тухай

Цагдаагийн ерөнхий газрын даргын 2014 оны 34 дүгээр тушаалаар баталсан “Цагдаагийн хүрээний дүрэм”-ийн 5 дугаар зүйлийн 5.1.1 дэх хэсгийн “г, е”, 2015 оны А/52 тушаалаар баталсан “Дүрэмт хувцас өмсөж хэрэглэх” журам” /код 917/-ын 917.2.8 дахь заалт, 2015 оны Б/99 дүгээр тушаалаар баталсан “Байгууллагын даргын тушаал гаргах журам” /код 136/-ын 136.4.2.дэх хэсгийн “а”, “е”, “к” заалт, 2016 оны Б/567 дугаар тушаалыг тус тус үндэслэн **ТУШААХ** нь:

1. Төв аймаг дахь Цагдаагийн газрын бие бүрэлдэхүүнийг 2016 оны 10 дугаар сарын 19-ний өдрөөс өвлийн улиралын дүрэмт хувцсанд шилжүүлэхийг хэлтэс, тасгийн дарга нарт зөвшөөрсүгэй.


2. Алба хаагчдын хувцсыг цаг агаарын байдалд тохируулан өмсгөж, хэрэглүүлэн жигдрюүлж, 2016 оны 10 дугаар сарын 21-ний дотор хувцасны үзлэгийг явуулж, дүнг 2016 оны 10 дугаар сарын 28-ны дотор Нийтийн хэв журам хамгаалах албаны дарга /туслах комисsar Б.Ганзориг/-д танилцуулахыг Нийтийн хэв журам хамгаалах тасгийн дарга /цагдаагийн дэд хурандаа Т.Лхагвасүрэн/-д үүрэг болгосугай.

3. Тушаалын хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг Төлөвлөлт, зохион байгуулалтын тасгийн дарга /цагдаагийн хурандаа Г.Эрхэмбаяр/-д үүрэг болгосугай.

4. Тушаалыг бие бүрэлдэхүүнд танилцуулсугай.

ДАРГА,
ЦАГДААГИЙН ДЭД ХУРАНДАА

Б.ГАНЗОРИГ



Tushaal

45000345